


## МӨНГӨНИЙ ТОЙМ

/2015 оны 8 дугаар сар/



## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014		2015							
	6-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар
<b>Инфляци</b>										
Улаанбаатар хотын инфляци										
сарын	0.5	0.6	0.5	0.2	0.8	0.8	0.1	0.1	0.1	0.1
оны эхнээс	6.0	10.7	0.5	0.7	1.5	2.4	2.5	2.6	2.7	2.8
жилийн	15.1	10.7	9.3	8.5	8.8	8.8	7.5	7.1	6.6	5.9
Суурь инфляци										
сарын	0.6	0.4	0.4	0.1	0.1	-0.1	0.0	0.1	0.1	2.4
оны эхнээс	3.3	12.6	0.4	0.1	0.5	0.4	0.4	0.5	0.6	2.9
жилийн	15.8	12.6	12.3	12.0	11.9	11.0	10.2	9.6	7.3	7.2
Улсын инфляци										
сарын	0.5	0.8	0.7	0.4	0.8	0.9	0.4	-0.1	0.0	0.1
оны эхнээс	6.7	11.0	0.7	1.1	1.9	2.9	3.3	3.2	3.3	3.4
жилийн	14.6	11.0	9.8	9.3	9.3	9.2	8.0	7.3	6.9	6.6
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр	10 107.0	10 635.8	10 314.6	10 230.5	9 903.7	9 705.0	9 845.8	10 041.3	9 862.0	9 964.4
сарын өөрчлөлт, %	-1.3	7.1	-3.0	-0.8	-3.2	-2.0	1.5	2.0	-1.8	1.0
жилийн өөрчлөлт, %	26.3	12.5	2.9	3.9	-0.5	-4.9	-3.9	-0.7	-2.1	-1.7
Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр	8 244.9	8 819.1	8 735.6	8 643.7	8 457.6	8 223.9	8 156.1	8 377.0	8 207.7	8 282.5
сарын өөрчлөлт, %	-2.0	7.0	-0.9	-1.1	-2.2	-2.8	-0.8	2.7	-2.0	0.9
жилийн өөрчлөлт, %	37.9	19.8	8.4	6.8	3.0	-1.6	-3.1	1.6	-2.1	0.3
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр	860.0	809.7	732.4	775.9	702.8	734.9	793.7	755.8	759.0	774.4
сарын өөрчлөлт, %	-0.3	5.3	-9.5	5.9	-9.4	4.6	8.0	-4.8	0.4	2.0
жилийн өөрчлөлт, %	2.9	-3.7	-18.1	2.5	-12.3	-12.7	-8.0	-12.1	-11.7	-12.0
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр	2 882.2	3 426.5	2 858.7	2 748.0	2 468.5	2 205.6	2 410.8	2 352.2	2 977.7	2 825.0
сарын өөрчлөлт, %	-4.2	27.9	-16.6	-3.9	-10.2	-10.7	9.3	-2.4	26.6	-5.1
жилийн өөрчлөлт, %	-17.9	2.7	-3.3	-12.2	-21.1	-15.1	-19.8	-18.4	2.5	0.4
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	12 302.1	12 502.5	12 088.8	12 176.9	12 271.4	12 296.7	12 176.1	11 947.7	11 992.4	11 840.8
сарын өөрчлөлт, %	2.0	-1.2	-3.3	0.7	0.8	0.2	-1.0	-1.9	0.4	-1.3
жилийн өөрчлөлт, %	42.9	16.1	9.8	9.2	7.8	4.8	0.9	-2.9	-1.9	-4.0
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар	4.61	5.00	5.44	5.48	5.73	6.08	6.07	6.48	6.88	7.31
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар (Хадгаламж, Зоос-ыг хассанаар)	2.72	3.10	3.51	3.56	3.90	4.23	4.20	4.60	5.00	5.40
<b>Хуу</b>										
Хадгаламжийн ЖДХ	12.2	12.5	12.7	12.8	12.9	12.9	12.8	12.9	12.9	13.0
Зээлийн ЖДХ*	18.8	19.5	20.0	19.0	19.1	20.2	19.8	19.8	19.4	20.1
Монголбанкны ҮГХ зээлийг оруулсан ЖДХ*	17.3	16.9	16.9	18.0	17.6	18.6	18.4	18.2	18.4	19.1
Ипотекийн зээлийн ЖДХ	10.5	9.9	10.2	9.7	9.2	9.6	10.3	9.6	9.9	10.0
ТБҮЦ-ны ЖДХ	10.6	12.1	12.3	13.1	13.1	13.1	13.0	13.0	13.0	13.0
Бодлогын хүү	10.5	12.0	13.0	13.0	13.0	13.0	13.0	13.0	13.0	13.0
БХЗ-ын ЖДХ	10.4	12.2	12.6	13.1	13.2	13.8	13.6	13.2	13.3	13.7


\* Төрсгийн зээлийн жингэсэн дундаж хүү

## Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2015 оны 8 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 3.4 хувь, өмнөх оны мөн үеэс 6.6 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 2.8 хувь, өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 2.4 хувь, оны эхнээс 2.9 хувь, жилийн 7.2 хувьтай байв.

**Тухайн сард** талх, гурилны үнэ 1.3 хувиар өсч харин махны үнэ 13.1 хувь, хүнсний ногооны үнэ 4.7 хувиар буурснаар хүнсний барааны бүлгийн үнэ 5.4 хувиар буурсан байна. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 2.6 хувиар өссөн нь дээд боловсролын үнэ 23.6 хувь өссөнтэй холбоотой.

Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 48 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 26 бараа үйлчилгээнийх буурсан байна.



**Жилийн инфляцийн** 11.9 хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 88.1 хувийг хүнснээс бусад барааны бүлгийн үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Боловсролын бүлгийн үнэ


23.6 хувь (жилийн өсөлтийн 30.8 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлш 12.7 хувь (жилийн өсөлтийн 28.6 хувь), хувцас, бөс бараа, гутал 4.4 хувь (жилийн өсөлтийн 9.7 хувь), гэр ахуйн тавилга, бараа 8.4 хувь (жилийн өсөлтийн 4.6 хувь), согтууруулах ундаа, тамхи 5.1 хувь (жилийн өсөлтийн 4.0 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 4.7 хувь (жилийн өсөлтийн 2.4 хувь), тээвэр 1.0 хувиар (жилийн өсөлтийн 1.9 хувь) тус тус өссөн байна. Харин холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.7 хувиар буурчээ.

Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурч жилийн инфляцийн 0.6 нэгж хувийг бүрдүүлжээ. Үүнийг задалж үзвэл, 0.8 нэгж хувийг хүнсний ногоо, 0.1 нэгж хувийг өөх, тос, -0.8 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт бүрдүүлсэн байна.

## Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 1.0 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурч 9964.4 тэрбум төгрөгт хүрчээ.


Мөнгөний нийлүүлэлтийн 50.9 хувийг төгрөгийн хадгаламж, 21.5 хувийг валютын хадгаламж, 12.4 хувийг төгрөгийн харилцах, 10.7 хувийг валютын харилцах, 4.5 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Тайлант сард гадаад валютын хадгаламжийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сарынхаас 10.5 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 1.9 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 1.4 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 0.4 нэгж хувиар өсчээ. Харин хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх -26.8 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл гадаад валютын хадгаламж 101.4 тэрбум төгрөг, гадаад валютын харилцах 51.8 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 32.6 тэрбум төгрөгөөр өссөн бол хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 5.0 тэрбум төгрөг, төгрөгийн хадгаламж 78.4 тэрбум төгрөгөөр буурчээ.

Нийт мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурсны 6.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -0.3 нэгж хувийг төгрөгийн харилцах, -2.3 нэгж хувийг гадаад валютын харилцах, -3.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламж тус тус бүрдүүлсэн байна.

### Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 0.3 хувь буюу 23.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 3.6 хувь буюу 253.2 тэрбум төгрөгөөр өсч 7217.7 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 4.5 хувь буюу 45.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 48.6 хувь буюу 912.4 тэрбум төгрөгөөр буурч 963.6 тэрбум төгрөгт, иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.8 хувь буюу 33.0 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 15.1 хувь буюу 540.3 тэрбум төгрөгөөр өсч 4111.3 тэрбум төгрөгт хүрчээ.



Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 5.0 хувь буюу 101.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 41.2 хувь буюу 625.4 тэрбум төгрөгөөр өсч 2142.8 тэрбум төгрөг болжээ.




Нийт хадгаламжийн 70.3 хувь нь төгрөгийн, 29.7 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 7.9 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 12.4 хувийг эзэлж буй төгрөгийн харилцах өмнөх сараас 2.7 хувь буюу 32.6 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 2.0 хувь буюу 25.6 тэрбум төгрөгөөр буурч 1233.2 тэрбум төгрөг болсон бол 10.7 хувийг эзэлж буй валютын харилцах өмнөх сараас 5.1 хувь буюу 51.8 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 17.9 хувь буюу 232.0 тэрбум төгрөгөөр буурч 1064.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.


### Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх сараас 0.9 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 3.6 дахин буурснаар -3215.8 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх сараас 2.0 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 26.9 хувиар буурч 6748.6 тэрбум төгрөг болов.



## Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 5.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсч 2825.0 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 1.1 хувь буюу 5.0 тэрбум төгрөг, Төв банк дахь харилцах, хадгаламж 7.6 хувь буюу 168.0 тэрбум төгрөгөөр буурсан бол банкуудын касс 6.7 хувь буюу 20.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар өсч 72.7 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 6.0 нэгж хувиар буурч 15.9 хувь, банкуудын кассын эзлэх хувь 2.1 нэгж хувиар буурч 11.4 хувьтай байна.

<sup>1</sup>Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.


## Зээл

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд оны эхнээс буурсаар 6-р сараас хасах утгатай болсон. Тайлант сард МИК ОССК-д 261.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шилжүүлснээр уг бууралт өмнөх сараас 2.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин МИК ОССК-д шилжүүлсэн зээлийг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өссөн байна.

Хадгаламжийн байгууллагуудаас <sup>1</sup> олгосон зээл өмнөх сарынхаас 1.3 хувь буюу 151.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 4.0 хувь буюу 497.6 тэрбум төгрөгөөр буурч 11.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Харин банкуудаас МИК ОССК-д шилжүүлсэн зээл<sup>2</sup>-ийг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл 13.6 их наяд төгрөг байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 0.3 хувь буюу 21.2 тэрбум төгрөгөөр өсч, өнгөрсөн оны мөн үеэс 1.9 хувь буюу 126.4 тэрбум төгрөгөөр буурч 6424.7 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 3.1 хувь буюу 171.5 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувь буюу 365.7 тэрбум төгрөгөөр буурч<sup>3</sup> 5296 тэрбум төгрөгт хүрсэн байна.

<sup>2</sup> МИК ОССК ИЗББ гарган банкуудаас ипотекийн зээлийг худалдан авсан нь 2015 оны 8-р сарын байдлаар 1.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

<sup>3</sup> МИК-д шилжсэн зээлийг оруулснаар 7054.1 тэрбум төгрөг байна.



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 54.3 хувь нь хувийн хэвшил, 44.7 хувь нь иргэд, 0.9 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна. Харин МИК-д шилжсэн ипотекийн зээлийг нийт зээлийн үлдэгдэлд оруулж тооцвол 47.2 хувь нь хувийн хэвшил, 51.9 хувь нь иргэдэд олгосон зээл байна.



Нийт зээлийн үлдэгдлийн 86.1 хувийг хэвийн зээл, 6.6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 7.3 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.3 нэгж хувиар

өссөн байна. МИК-д шилжсэн ипотекийн зээлийг оруулж тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 6.4 хувьтай байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 5.4 хувьтай байна.

### Картын зээл

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн үлдэгдлийн 1.9 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл тайлант сард 229.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар буюу 51.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 0.1 хувиар буюу 0.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Картын зээлийн 93 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 4.6 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 93.7 хувь нь төгрөгөөр, 6.3 хувь нь валютаар олгогдсон байна.

## Хүү


Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2015 оны 8 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсч жилийн 13.02 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсч жилийн 20.1<sup>4</sup> хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурч жилийн 12.2 хувь болжээ.

Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 3.0 хувь, валютынх жилийн 1.6 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсч жилийн 13.0 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсч жилийн 6.5 хувь болов.

## Мөнгөний зах

2015 оны 8 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 918.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 13.74 хувь байна.

<sup>4</sup> Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол



2015 оны 7 сарын 22-ны өдрөөс 2015 оны 9 сарын 1-ны өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 879.9 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд дунджаар 410.6 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 882.9 тэрбум төгрөг, валютын нөөцөд дунджаар 938.0 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

## Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2015 оны 8 дугаар сарын эцэст 1991.49 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 180.5 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 1990.48 төгрөг байв.

төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 19.1 хувь байна.

